

Эрүүл ахуйн хамгаалалтын бүсийн
заагийг тогтоох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.1.8, 35 дугаар зүйлийн 35.1.14, 48 дүгээр зүйлийн 48.1, Усны тухай хуулийн 11 дүгээр зүйл 11.1.3, 11.1.4, Захиргааны Ерөнхий хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1, 60 дугаар зүйлийн 60.1 дүгээр зүйл, Байгаль орчин, ногоон хөгжил, аялал жуучлалын сайд, Барилга, хот байгуулалтын сайдын 2015 оны А-230/127 хамтарсан тушаалаар батлагдсан журмын 3 дахь хэсгийн 3.1, 3.14, Байгаль орчин, ногоон хөгжил, аялал жуучлалын яамны төрийн нарийн бичгийн даргын 2019 оны А/489 дүгээр тушаал, Байгаль орчин, аялал жуулчлалын яамны Төрийн нарийн бичгийн даргын 2021 оны 03/3815 дугаар “Хүн амын ус хангамжийн эх үүсвэрийн эрүүл ахуйн хамгаалалтын бүс тогтоох тухай”, Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2022 оны 01/3410 дугаар “Хүн амын ус хангамжийн эх үүсвэрийн эрүүл ахуйн хамгаалалтын бүс, тэжээгдлийн мужийг тогтоох тухай дүгнэлтийн тухай”, Барилга, хот байгуулалтын яамны Төрийн нарийн бичгийн даргын 2021 оны 3/2355 дугаар “Чиглэл хүргүүлэх тухай”, Барилга, хот байгуулалтын сайдын 2022 оны 1/5059 дүгээр “Дүгнэлт хүргүүлэх тухай” дүгнэлтүүдийг тус тус үндэслэн сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит бус XII хуралдаанаас ТОГТООХ нь:

1. Шарын гол сумын хүн амын төвлөрсөн ус хангамжийн эх үүсвэрийн ашиглалтын худгуудын эрүүл ахуйн хязгаарлалтын бүсийн нийт 422.6 га талбайн хэмжээ, хил заагийн эргэлтийн цэгүүдийн солбицлыг нэгдүгээр хавсралтаар, кадастрын зургийг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.
2. Төвлөрсөн ус хангамжийн эх үүсвэрийн худгуудын эргэн тойронд эрүүл ахуйн хязгаарлалтын бүс тогтоосонтой холбогдуулан бүсийн дэглэмийг мөрдөж ажиллахыг “ Дулаан Шарын гол ” ТӨХК-ний захирал (Б.Батхуяг) - т даалгасугай.
3. Төвлөрсөн ус хангамжийн эх үүсвэрийн эрүүл ахуйн бүсийн дэглэмтэй холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Засаг дарга (Б.Лхамсүрэн)-д үүрэг болгосугай
4. Ундны усны эх үүсвэрийн хязгаарлалтын бүстэй давхцалтай хэсгийн талбайг тусгай зөвшөөрлөөс хасуулах ажлыг холбогдох байгууллагад мэдэгдэж шийдвэрлүүлэхийг Засаг дарга (Б.Лхамсүрэн) -д үүрэг болгосугай.
5. Энэ тогтоол гарсантай холбогдуулан сумын ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2016 оны 19, ИТХ-ын 2018 оны 28, ИТХ-ын 2021 оны 21 дүгээр тогтоолуудыг тус тус хүчингүй болгосугай.
6. Тогтоолыг Захиргааны ерөнхий хуулийн дагуу Хууль зүй, дотоод хэргийн яаманд хүргүүлэн, захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн бүртгэлд бүртгүүлэхийг ИТХ-ын нарийн бичгийн дарга (Б.Болорчимэг)-т үүрэг болгосугай.

ДАРГА

Г. МӨНХЖАРГАЛ

Сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын
8 дахь удаагийн сонгуулийн ээлжит бус 12 дугаар
хуралдаанытогтоолын нэгдүгээр хавсралт

Д/д	Цэгийн дугаар	Уртраг	Өргөрөг	UTM T48	
				X	Y
1	1	106 26 19.9	49 11 32.25	604834.6	5449828.82
2	2	106 26 22.77	49 11 39.74	604888.29	5450061.21
3	3	106 26 19.99	49 11 47.74	604827.33	5450307.17
4	4	106 26 18.73	49 11 57.71	604795.98	5450614.55
5	5	106 26 18.42	49 12 8.98	604783.09	5450962.43
6	6	106 26 18.31	49 12 20.89	604773.88	5451330.16
7	7	106 26 26.45	49 12 32.56	604931.71	5451693.65
8	8	106 26 44.67	49 12 36.95	605297.73	5451836.24
9	9	106 27 0.36	49 12 32.79	605617.61	5451713.86
10	10	106 27 8.89	49 12 20.19	605797.65	5451328.09
11	11	106 27 7.99	49 12 7.65	605786.88	5450940.52
12	12	106 27 8.399	49 11 57.38	605801.24	5450623.55
13	13	106 27 9.399	49 11 50.39	605825.62	5450408.10
14	14	106 27 11.83	49 11 44.49	605878.31	5450226.86
15	15	106 27 9.04	49 11 36.57	605826.54	5449981.21
16	16	106 27 16.84	49 11 29.57	605988.55	5449768.09
17	17	106 27 23.56	49 11 20.704	606129.82	5449496.94
18	18	106 27 31.74	49 11 12.12	606300.49	5449235.06
19	19	106 27 33.704	49 11 3.96	606345.10	5448983.86
20	20	106 27 33.06	49 10 55.59	606337.05	5448725.15
21	21	106 27 29.47	49 10 44.21	606271.15	5448372.35
22	22	106 27 19.68	49 10 37.56	606076.91	5448163.19
23	23	106 27 04.93	49 10 35.13	605779.61	5448081.89
24	24	106 26 45.39	49 10 34.76	605384.39	5448063.43
25	25	106 26 29.00	49 10 37.868	605050.60	5448153.11
26	26	106 26 13.30	49 11 23.68	604706.11	5449561.74
27	27	106 26 14.96	49 11 25.41	604738.64	5449615.71

Нийт талбай 422.6 га

Сумын төвлөрсөн ус хангамжийн эх үүсвэрийн худгуудын
эрүүл ахуйн хамгаалалтын бүсийн хил заагийн зураг

